



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 03 сарын 26

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Оюун даргалж, хувьцаа эзэмшигч Б.Зориг /768564/, Д.Тунгалаг /99192/, Д.Оюун /1279/, Д.Төмөр-Очир /5/, Ж.Энхтунгалаг /1/, Ж.Баатар /2/, Б.Ганболд /1/ нарыг оролцуулан, хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунаар хөтлүүлэн “Материалимпэкс” ХК-ийн хурлын танхимд 2024 оны 03 сарын 26-ны өдрийн 10 цаг 45 минутад хийв.

Ашигласан цахим хаяг: ZOOM-meeting /927 254 1129/

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд, ХЭ-ийн ээлжит хурлын дэгийг танилцуулаад брокер дилерийн компаниудаар хурлын материал, дэгийг илгээсэн. Одоо оролцож байгаа хүмүүс урьдчилан танилцсан гэж найдаж байна.

Хурлаа эхлүүлэхээс өмнө тооллогын комиссын гишүүдээ танилцуулъя гээд Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэл нягтлан бодогч мэргэжилтэй, “Материал Гласс” ХХК-ийн нягтлан бодогч ажилтай, П.Сумъяасугар тус компанийн Гадаад харилцаа, тээвэр ложистикийн хэлтэст тээврийн менежерээр ажилладаг, манай компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн болон ашиг сонирхлын зөрчилгүй, манай компанийн хувьцаа эзэмшдэггүй, тооллогын комиссын гишүүн П.Сувдаа тус компанийн эрүүл ахуйчаар ажилладаг, тооллогын комиссын гишүүд бүгдээрээ манай компанийн хувьцаа эзэмшдэггүй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Одоо цаг 10 цаг 45 минут болж байна, комиссын дарга, гишүүд ирцийн бүртгэлийг дуусгаж, ирцийн мэдээгээ танилцуулъя.

Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нэгбүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийв. Ирцийн ажиллагаа 10:00 цагаас эхэлсэн болно.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Ирцийн мэдээллийг хуралд танилцуулж, 869,044 ширхэг саналын эрх бүхий хувьцаатай 07 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Ирцийн дүн 63,51% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Тооллогын комисс ирцийн бүртгэлээ хийж, ирцийн мэдээгээ танилцууллаа
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
- “Материал импекс констракшн” ХХК-ийн дүрмийг шинэчлэн батлах
- Ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлэл, тайлбар сонсох
- Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариулт
- Тооллогын комиссоос, саналын хуудсыг бөглөх зааврыг өгч санал хураалт явагдана.
- Саналын хуудас тоолох явцад хурал түр завсарлана.
- Тооллогын комиссоос саналын хуудасны дүнг танилцуулна.

- ХЭХ-аас гарах тогтоолыг танилцуулж, батлуулна.
- Хурлыг хаана. Ийм дарааллаар өнөөдрийн хурал явагдана.

Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Биржийн сайтад байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан. Өдрийн сонинд 2024.02.19 болон 2023.04.04-ний өдрүүдэд хурлын зар байршуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг нийтэд мэдээлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд компани дээр хурлын материалыг хэвлэж бэлдсэн байсан боловч хэн ч ирж танилцаагүйг тэмдэглэлд мөн тусгуулъя. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг гэдгийг дахин хэлье. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхтэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын дэгтэй холбоотой саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэцгээв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дарааллын талаар асуух асуулт байхгүй бол нэг дэх асуудалдаа оръё. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг миний бие хэлэлцүүлнэ. /ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав/.

Даргалагчаас: Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтээс асуух асуулт байна уу?
Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Нэмж хэлэхэд манай байгууллага уламжлал ёсоороо өмнөх оны сүүлээр дараа оныхоо арматурын татан авалтаа хийдэг 2023 онд ч мөн адил эрт татан авалтаа хийсэн байсан боловч барилгын ажил эхлэх үед арматурын үнэ унаснаас бид борлуулалтаа хийж чадахгүй байдалд хүрсэн учраас барилгын төсөлд хамтарч байсан байгууллага болон өөрийн хэрэгжүүлэх төсөлдөө арматураа хэрэглэж байсан. Гадагшаа бага хэмжээний борлуулалт хийсэн нь өртөгөөсөө багасгаж алдагдалтай борлуулалт хийсэн гэсэн үг.

Тээвэр зуучлалын хувьд талбай харгалзахгүй ачаа тээвэр буулгаснаас ачаалал маш их байсантай холбоотой ашиг орлого ч тэр хэмжээгээрээ нэмэгдсэн. Үндсэндээ манай гол нэрийн бараа арматурын алдагдлыг тээвэр зуучийн салбар маань нөхөж, компани ашигтай ажиллахад нөлөөлсөн, үндсэн дүнгээрээ компани ашигтай ажиллажээ гэж ТУЗ-өөс дүгнэж байна. тоон дүнг Аудитын хорооны дүгнэлтэд тусгагдсан учраас давхардуулахгүйгээр үлдээе.

Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор асуух асуулт байвал хэдийд ч тавьж болно шүү. ТУЗ-ийн дүгнэлттэй холбоотой асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг аудитын хорооны гишүүн П.Баатарцэрэнгээс хэлэлцүүлнэ.

П.Баатарцэрэнгээс: Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцүүлэв /дүгнэлтийг хавсаргав/. Асуух асуулт байгаа эсэхийг тодруулахад

Оролцогчдоос: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлье. Уг нь хурлын товд гүйцэтгэх захирал Б.Зоригоос хэлэлцүүлэх байсан боловч өнөөдөр захирал эрүүл мэндийн шалтгаантай байгаа тул би хэлэлцүүлье.

Энэ жил бид бизнес төлөвлөгөөгөө өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна тоотой буюу үнийн дүнгээр гаргасан онцлогтой. Үйл ажиллагаа бол явдагаараа л явна, гэхдээ хэдий хэр хэмжээний орлого олж, зардал гаргахын, дараа жил бид энэ жилийн төлөвлөгөөг хэчинсэн хувь биелүүлсэн байна гэх зэргээр дүгнэлт хийж, үйл ажиллагааны чиглэлээ нэмэгдүүлэх, зорилгоо илүү тодотгох зорилгоор тоон дүнтэй төлөвлөгөө гаргасан байгаа.

Гэхдээ өнөөдөр би хурлаар тогтмол үйл ажиллагаа явуулдаг хэлтэс нэгжүүдээс гадна худалдааны болон тээвэр зуучийн хэлтсийн төлөвлөгөөг илүү дэлгэрэнгүй танилцуулсан нь зөв гэж бодлоо. Учир нь гол мөнгөн дүнгээрх орлого зарлага энэ 2 хэлтэс дээр явагддаг, бусад

хэлтсүүд маань тогтмол, үйлчилгээний үйл ажиллагаатай юм гээд Худалдааны болон Гадаад харилцаа, тээвэр ложистикийн хэлтсийн төлөвлөгөөг дэлгэрэнгүйгээр нийт компанийн бизнес төлөвлөгөөг тоон үзүүлэлт нэгбүрчлэн тайлбарлан хэлэлцүүлэв /хавсаргав/.

Бизнес төлөвлөгөөнөөс асуух асуулт байна уу?

Оролцогчид: Одоохондоо асуух асуулгүй гэв.

Даргалагчаас: Манай бетон зуурмагийн үзель энэ байршилдаа зуурмаг зуурах боломжгүй болсон, эрх бүхий байгууллагаас үйл ажиллагаа явуулахыг хориглосон учраас бид үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Мөн тээвэр зуучийн байгууллагуудыг хотоос гаргах асуудал 10 гаруй жилийн өмнө яригдаж байгаад нэг хэсэг чимээгүй болсноо одоо дахиад эрчимтэй яригдаж эхэлсэн. Ямар ч нөхцөлд хотоос гаргасан тохиолдолд манай компанийн хэвийн үйл ажиллагаа доголдоход шууд нөлөөлөх учраас бид энэ жилээс арматур, тээвэр зуучаас өөр ямар салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулах болмोजтой, бид чадамжтай гэдгийг багагүй хугацаанд судалсны үндсэн дээр олон үйл ажиллагааг төлөвлөсөн. Тухай бүрт яригдаад байгааг анзаарч байгаа байх. Хүнсний бөөний худалдааг жижиглэн болон хүргэлтээр, барилга угсралтын салбарт өөрийн охин компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, барилгын төслүүдэд оролцох, хөрөнгө оруулалт хийх гэх мэт олон судалгааг хийж, эхнээс нь хэрэгжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл бид ганцхан арматур болон тээвэр зуучийнхаа үйл ажиллагаанд найдаж болохгүй гэдгийг ойрын жилүүдийн үйл явц харуулсаар байгаад дүгнэлт хийсэн гэдгийг тодруулан хэлье.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. ТУЗ-ийн 2024 оны төсөв, дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээг батлах асуудлыг ЦУХорооны дарга Ц.Ариунаагаас хэлэлцүүлэе.

Ц.Ариунаагаас: 2024 оны ТУЗ-ийн төсөлийн гаргахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах цаг үеийн шаардлага гарч болзошгүй нөхцөл байдалтай уялдуулан гаргасан гэдгийг дурдаад дэлгэрэнгүй тоон үзүүлэлтүүдийг хэлэлцүүлэв. /ЦУХ-ны саналыг хавсаргав/

Даргалагчаас: ТУЗ-ийн төсөвтэй холбоотой асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: “Материал импекс констракшн кредит” ХХК-ийн дүрмийг шинэчлэн батлах асуудлыг компанийн хуульч Т.Лхагвачулуунаас хэлэлцүүлэе.

Т.Лхагвачулуунаас: Манай Материалимпекс ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалт, үүсгэн байгуулалтай Материалимпекс констракшн ХХК үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа. Бидний төлөвлөгөөнд тусгагдсан буюу хэрэгжүүлж эхэлсэн зарим нэг төсөлтэй холбоотойгоор төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагааны чиглэл нэмэх нь зөв юм байна гэж үзсэн. Гэтэл толгой компанийн ХЭХ-ын шийдвэр зайлшгүй шаардлагатай хуулийн заалтын хүрээнд өнөөдрийн хурлаар хэлэлцүүлж байгаа. МИК ХХК-ийн дүрэм 2016 онд батлагдсан, уг дүрэмд зөвхөн үйл ажиллагааны чиглэл нэмсэн гэдгийг тодруулан хэлж байна. Хаягийн тухайд хуучин 04 дүгээр хороо маань задарч 25 дугаар хороо болсон, өөр нэмэгдэж хасагдаж, өөрчлөгдөж байгаа зүйл шинэчлэн батлах дүрэмд байхгүй.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ХХК болон ХК-ийн дүрмийн үлгэрчилсэн загварыг гаргасан байдаг, тэрхүү загварын дагуу батлагдсан дүрмийг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл нэмүүлэхээр хэлэлцүүлж байна гэв.

Даргалагчаас: Нэмж хэлэхэд манай констракшн дээр барилга угсралтын тусгай зөвшөөрөл байдаг шүү.

Асуух асуулт байна уу?

Оролцогчид: Ойлгомжтой байна, асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Ногдол ашгийн талаарх мэдээллийг аудитын хорооны дарга Б.Энх-Амараас мэдээлье.

Б.Энх-Амараас: 2023 оны компанийн үйл ажиллагаа ашигтай гарсан хэдий ч бид шинээр 2-3 барилгын төсөлд оролцох, бетон зурмагийн үйлдвэрээ нүүлгэн шилжүүлэх юм уу газар худалдан авч болзошгүй нөхцөл байдал үүссэн, мөн тээвэр зуучийн үйл ажиллагааг хотоос

гаргахтай холбоотой мөн нүүх болон кран тоног төхөөрөмж худалдан авах, үйлчилгээний төвийн барилгыг өнөөдрийг хүртэл байнгын ашиглалтад хүлээн аваагүй он дамжин явагдаж байгаа зэрэг нөхцөл байдлуудыг үндэслэн, ирээдүйн өгөөжийг тооцоолсноор бид энэ удаад ногдол ашиг тараахгүйгээр 2024 оны бүтээн байгуулалт, үйл ажиллагаагаа дэмжихэд чиглэсэн зүйтэй юм гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс үзсэн учраас тараахгүй байх шийдвэр гаргасан гэв.

Даргалагчаас: Дээр хэлэлцсэн асуудлуудад дурдагдаад л байсан, бид үйл ажиллагаагаа зөвхөн арматур, тээвэр зуучаар төсөөлж болохгүй юм байна, хэрэв энэ 2 гол үйл ажиллагаа доголдоход бид ажилчдын цалин хөлс, тогтмол гарах зардлуудаа хэрхэн ямар эх үүсвэр орлогоос шийдвэрлэх вэ гэдэг бидний анхаарах хамгийн гол асуудал мөн. Ийм учраас бид ашигтай ажиллаж байгаа жилүүддээ ирээдүйд олох ашгаа тооцоолон хөрөнгө оруулалтаа хийж байх нь зүйтэй. Төрийн ганц байгууллага өөрийн эрх ашгийн хүрээнд хувийн хэвшлийг хэрхэн хяхан боогдуулж чадаж байгааг бид бэлхнээ өөрсдийн биеэр мэдэрч, үзэж байна. манай үйлчилгээний төвийн асуудал байна, одоо дээрээс нь орон сууцны барилгын асуудлыг гацаасан, цаашилбал манай төмөр замын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулахад хүртэл нөлөөлж байна. Иймд хөрөнгө оруулалтыг илүүд үзэж, ногдол ашгийг хуваарихгүйгээр шийдвэрлэсэн. Асуух асуулт байна уу?

Б.Ганболдоос: Энэ жилийн ашиг хэд байсан билээ?

Б.Энх-Амараас 4,7 тэрбум төгрөг гэв.

Бусад оролцогчид: Асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлууд дууслаа, асуулт хариултын дараалалдаа орьё. Одоо нийтээр нь сонсоод асуух зүйл гарсан байж магадгүй. Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт, санал, хүсэлт аль нь ч байж болно.

Ж.Баатараас: За манай компани гайгүй сайн ажиллаж байгаа юм байна гэж ойлгож байна. Борлуулалтын орлого арматурын борлуулалт муудсантай холбоотой худалдааны хэлтсээс оруулж ирсэн төлөвлөгөө их зөв санагдаж байна. Үүнийг компаниас дэмжиж төлөвлөгөөндөө тусгасан нь сайн зүйл болжээ гэж харж байна. Тээвэр зуучлалын тухайд Япон улсаас компани өөрсдөө автомашин оруулж ирэх асуудалд хувьдаа дэмжиж байна, хэн бүхэн жижиг машин авч л байдаг, би жишээ нь өөрөө машинтай, машин авах бол компаниасаа худалдаад авахад эргээд компанийхаа үйл ажиллагааг дэмжиж байгаа хэрэг шүү дээ гэю.

Б.Ганболдоос: Тээвэр зууч нүүлээ гэхэд нүүлгэх газар нь манайх үйл ажиллагаагаа явуулах боломж гарах болов уу?

Б.Зоригос: Уг нь анх энэ асуудал 10 гаруй жилийн өмнө яригдахад тээвэр зуучийн үйл ажиллагаа явуулдаг 22 компани хамтарч УБ хотын тээвэр логистикийн нэгдсэн төв гэж компани байгуулж байсан. Тухайн үед Туушин компанийн 130 байхаа гар газарт үйл ажиллагаа явуулна гэж байсан, уг 22 компани ижил тэнцүү 2% эзэмшихээр тухайн үедээ тохиролцож байсан ч нийслэлтэй тохиролцож чадаагүйгээс чимээгүй болж, улмаар дээрх компани 2018 билүү 2019 онд татан буугдсан байдаг. Өнгөрсөн жилээс хотоос гаргах асуудал дахиад эрчимтэй яригдаж эхэлсэн, манайх шиг ГХБ-ийн талбайтай 9 байгууллагыг Нийслэлээс санаачлан дуудаж, 2 ч удаа уулзалт зохион байгуулсан. Одоо ажлын хэсэг байгуулагдсан байгаа бөгөөд манай компанийн төлөөлөл уг ажлын хэсэгт багтсан байгаа. Миний ойлгосноор 2 асуудал эргэлзээтэй байна гэж ойлгосон, 1-т нөгөө Туушин компанийн 130 га газрын яг хажууд утаагүй түлшний үйлдвэр байгаа юм байна. Утаагүй түлшний үйлдвэрийн тортог, тоосжилт 10км-ын радиуст цацагддаг гэнэ. Тэгэхээр чингэлэг, вагоноор хүнсний бүтээгдэхүүн буух тохиолдолд норм, стандартын шаардлагад нийцэхгүй л болов уу. 2-т, Тээвэр зуучийн байгууллагууд эхний ээлжид хөрөнгө оруулах эрхтэй, гэтэл 205 тэрбум төгрөгөөр уг терминалийн үйл ажиллагаа явагдана гэж байгаа. Гэтэл Туушин компани газрын төлбөрт 10 гаруй жилийн хугацаанд 40-42 тэрбум төгрөг төлсөн байгаа, үүнийг хөрөнгө оруулалтад тооцуулах асуудал яригдаж байгаа. Тэр байгууллагын төлчихсөн газрын төлбөрийг бид өнөөдөр яагаад хөрөнгө оруулалт гэж үзэх ёстой юм мэдэхгүй.

Мөн тээвэр зуучийн байгууллагуудын нэгдсэн холбоо байдаг, тэр холбоо нийслэлтэй санамж бичиг байгуулсан. Ямар нэгэн шийдвэр гарвал бид шийдвэрийг дагаж хотоос гарах нь

гарцаагүй гэдэг нь л ойлгомжтой асуудал болсон. Энэ талаар олон нийтийн хэвлэл мэдээллийг хэрэгслээр яригдаад л байгаа тул та бүхэн ч бас сонсож л байгаа байх гэв.

Б.Ганболдоос: Энэ жил барилгын салбар хэр байх төлөвтэй байна?

Б.Зоригос: Одоогийн төсөөллөөр бол гайгүй байх шинжтэй байна, гэхдээ сонгуультай холбоотой гайгүй харагдаж болох талтай гэв.

Ж.Баатараас: Хүнсний бараандаа түгээлт хийнэ гэсэн үү?

Даргалагчаас: Тийм ээ, борлуулалтын олон сувгийг нээхээр хичээн ажиллаж л байна.

Б.Ганболдоос: Шинээр өргөн баригдах үнэт цаастай холбоотой хуулиудад жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашиг, дуу хоолой нэмэгдэж байгаа. Үүнтэй холбоотойгоор жижиг хувьцаа эзэмшигч бидний дуу хоолой хэрэгтэй үед бид компанийхаа төлөө, бусад хувьцаа эзэмшигчдийнхээ төлөө нэгдэхэд бэлэн байгаа. Ялангуяа энэ газартай холбоотой, төрийн эрх бүхий байгууллагын хууль бус үйлдэлтэй холбоотой асуудлуудад бид оролцоотой байх болно гэдгээ хэлмээр байна. Би хувьдаа жишээ нь энэ үйлчилгээний төв яагаад ашиглалтад орохгүй байгаа талаар мэдэх гэж өнөөдрийн хуралд ирсэн, шалтгааныг сонслоо гэв.

Даргалагчаас: Асуух асуулт, санал хураалт дууссан бол санал хураалтдаа оръё. Тооллогын комиссоос саналыг хуудсыг тараая.

Тооллогын комиссын гишүүдээс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тарааж, бөглөх зааврыг танилцуулав.

Санал хураалт 11:55 цагт эхлэв.

Хурал 12:00 цагт завсарлаж, хурал 12:05 цагт үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Саналын хуудаснуудаас 07 саналын эрх бүхий 07 саналын хуудсыг хүчинтэйд тооцож,
2. Хүчингүйд тооцсон саналын хуудас байхгүй болохыг дурдаад,
3. Хүчинтэйд тооцсон саналын хуудсаар өгсөн санал хураалтыг тоолоход хэлэлцүүлж буй асуудлыг доорх хувиар зөвшөөрснийг тогтоов. Үүнд :

3.1 Компанийн 2023 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.3 Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.4 ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээ, баталсан 100 хувь

3.5 “Материал импекс констракшн” ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан – 100%.

Даргалагчаас: Тооллогын комиссын дүн, тогтоолтой холбоотой асуух асуулт байна уу? Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах тогтоолууд гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталж,

2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,

3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02. Утга:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээ, 2024 оны үйл ажиллагааны нийт төсвийг 270,000,000 /Хоёр зуун далан сая/ төгрөгөөр баталж,

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, төсвийг үр ашигтай захиран зарцуулахыг үүрэг болгов.

Тогтоол №03. Утга нь:

1. "Материал импекс констракшн" ХХК-ийн "Дүрэм"-ийг Хавсралтаар шинэчлэн баталж,
2. "Материал импекс констракшн" ХХК-ийн гүйцэтгэх захирал Баярын Зориг хэвээр болохыг дурдаад,
3. Шинэчлэн батлагдсан дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдөж,
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотой "Материал импекс констракшн" ХХК-ийн 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан дүрмийг хүчингүйд тооцоод,
5. "Материалимпэкс" ХК /хувьцаа эзэмшигчид/-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх захирал Баярын Зориг болохыг дурдав.

Даргалагчаас: Хурлаас гарч буй тогтоолыг ХЭ-дээсээ гар өргөж давхар баталгаажуулъя.
Тогтоол №01, 02, 03-ыг батлах уу?

Бүх гишүүд: 100% гар өргөн батлав.

Даргалагчаас: Ингээд хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 35 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

Д.ОЮУН